



**МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 08 сарын 24 өдөр

Дугаар A/92

Улаанбаатар хот

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн “Техникийн нөхцөл олгох,
ажил хүлээн авах нийтлэг журам шинэчлэн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн “Техникийн нөхцөл олгох, ажлын гүйцэтгэлд хяналт тавих, хүлээн авах нийтлэг журам”-ыг Нэгдүгээр хавсралтаар, Техникийн нөхцөлийн маягтын загварыг Хоёрдугаар хавсралтаар, Ажил эхлүүлэх зөвшөөрлийн маягтын загварыг Гуравдугаар хавсралтаар, Гүйцэтгэлийн актын загварыг Дөрөвдүгээр хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалыг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Технологийн удирдлага, төлөвлөлтийн газрын захирал (А.Гантулга)-д үүрэг болгосугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2016 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/35 дугаар тушаал, Улаанбаатар хот дахь салбарын даргын 2017 оны 03 дугаар сарын 27-ны А/05 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.МӨНХБАТ

NETCOM

000000806

“Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын
2022 оны 08 сарын 16 ны өдрийн
А/92 дугаар тушаалын Нэгдүгээр хавсралт



ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОХ, АЖИЛ ХҮЛЭЭН АВАХ НИЙТЛЭГ ЖУРАМ

Агуулга:

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

ХОЁР. ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОХ КОМИСС

ГУРАВ. ТЕХНИКИЙН НӨХЦӨЛИЙН ТӨРӨЛ

ДӨРӨВ. ТЕХНИКИЙН НӨХЦӨЛИЙН ХҮСЭЛТИЙГ ХҮЛЭЭН АВАХ

ТАВ. ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ХҮСЭХЭД БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

ЗУРГАА. ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ДОЛОО. ТЕХНИКИЙН НӨХЦӨЛИЙГ БАТЛАХ, ОЛГОХ

НАЙМ. ТЕХНИКИЙН НӨХЦӨЛИЙН ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

ЕС. ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ӨӨРЧЛӨХ, ХУГАЦААГ СУНГАХ, ЦУЦЛАХ

АРАВ. ТЕХНИКИЙН НӨХЦӨЛИЙН ХУРААМЖ

АРВАН НЭГ. “В”, “С”, “D” ТӨРЛИЙН ТЕХНИКИЙН НӨХЦӨЛИЙН ДАГУУ ГАДНА

ХОЛБООНЫ АЖЛЫН ЗУРАГ, ТӨСӨВ ЗӨВШИЛЦӨХ

АРВАН ХОЁР. ГАЗАР ШОРООНЫ АЖЛЫН ТОДРУУЛГА АВАХ

АРВАН ГУРАВ. АЖИЛ ЭХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ХЯНАЛТ ТАВИХ

АРВАН ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭЛИЙГ ТЕХНИКИЙН АКТААР ХҮЛЭЭН АВАХ

АРВАН ТАВ. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ УЛСЫН КОМИССТ
АЖИЛЛАХ

АРВАН ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

АРВАН ДОЛОО. АВЛИГА АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмаар Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн дамжуулах сүлжээгээр суваг урсгалын үйлчилгээ авах болон барилга байгууламж, цамхаг, сайт, зай тэжээл, худаг сувагчлал, кабель шугамын байгууламжийн сүлжээнд холбогдох, тэдгээрийг түрээслүүлэх шинээр барьж байгуулах, шилжүүлэх ажилд техникийн нөхцөл олгох, чанарын хяналт тавих, ашиглалтад хүлээн авахтай холбоотой харилцааг зохицуулна.

Хоёр. Техникийн нөхцөл олгох комисс

2.1 Улаанбаатар хотод техникийн нөхцөл олгох комиссын бүрэлдэхүүнийг Гүйцэтгэх захирлын тушаалаар томилно.

2.2 Аймаг, орон нутаг, дүүргийн газруудад техникийн нөхцөл олгох комиссын бүрэлдэхүүнийг тухайн газрын даргын тушаалаар томилно. 2.3 Техникийн нөхцөл олгох комисс нь Улаанбаатар хотод 7 хоногт нэгээс доошгүй удаа, аймаг орон нутагт тухай бүрт хуралдаж шийдвэр гаргана.

Гурав. Техникийн нөхцөлийн төрөл

3.1 Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-аас олгох техникийн нөхцөлүүд:

3.1.1 **“LLC”**-Суваг түрээсийн үйлчилгээ (Нэг техникийн нөхцөлд 5 хүртэлх чиглэл байна);

3.1.2 **“IS”**-Интернэтийн бөөний үйлчилгээ (Нэг техникийн нөхцөлд 5 хүртэлх чиглэл байна);

3.1.3 **“LC”**-Шилэн кабелийн шөрмөс түрээсийн үйлчилгээ (Нэг техникийн нөхцөлд 5 хүртэлх чиглэл байна);

3.1.4 **“ESR”**-Тоног төхөөрөмжийн байр талбай, цамхаг түрээсийн үйлчилгээ;

3.1.5 **“OR”**-Дэд бүтэц, барилга байгууламжийн түрээсийн үйлчилгээ;

3.1.6 **“A”**-Сувагчлалаар шилэн кабель суурилуулах (Нэг техникийн нөхцөлд нийслэлд 5 хүртэлх, орон нутагт 2 хүртэлх чиглэл байна);

3.1.7 **“B”**-Худаг сувагчлал байгуулах, физик кабель суурилуулах;

3.1.8 **“C”**-Худаг сувагчлал, кабель шугамын байгууламжийг хамгаалах, шинээр хийх, шилжүүлэх;

3.1.9 **“D”**-Худаг сувагчлал байгуулах;

Дөрөв. Техникийн нөхцөлийн хүсэлтийг хүлээн авах

4.1 Хуулийн этгээд, иргэний Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-аас олгох техникийн нөхцөл хүсэлтийг:

- 4.1.1 Компанийн бичиг хэргээр дамжуулж;
- 4.1.2 Аймаг, дүүргийн газруудын бичиг хэргээр дамжуулж;
- 4.1.3 Төрийн үйлчилгээний нэгдсэн төвүүд (Дүнжингарав, Мишээл, Драгон);
- 4.1.4 Компанийн www.icp.mn цахим хуудсаар хүлээн авна.

Тав. Техникийн нөхцөл хүсэхэд бүрдүүлэх материалын жагсаалт

5.1 Хуулийн этгээд, иргэн нь техникийн нөхцөл хүсэхдээ дараах нийтлэг материалыг бүрдүүлнэ. Үүнд:

- 5.1.1 Хуулийн этгээд бол албан бичиг, иргэн бол хүсэлт;
- 5.1.2 Үйлчилгээний хураамж төлсөн баримт;

5.2 "А" техникийн нөхцөл хүсэхэд дараах материалыг нэмэлтээр хавсаргана. Үүнд:

5.2.1 Шилэн кабелийн холболтын эхлэл, төгсгөлийн цэгийн мэдээлэл, координат (Google earth);

5.3 "В", "С", "D" техникийн нөхцөл хүсэхэд дараах материалыг нэмэлтээр хавсаргана. Үүнд:

- 5.3.1 Архитектур төлөвлөлтийн даалгавар;
- 5.3.2 Барилгажих талбайн схем зураг (Архитектур төлөвлөлтийн даалгаврын хавсралт);
- 5.3.3 Газрын гэрчилгээний хуулбар;
- 5.3.4 Кадастрын зураг;

5.4 "IS" техникийн нөхцөл хүсэхэд дараах материалыг нэмэлтээр хавсаргана. Үүнд:

- 5.4.1 Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх "Б" ангиллын тусгай зөвшөөрөл;

Зургаа. Техникийн нөхцөл боловсруулах үйл ажиллагаа

6.1 Хуулийн этгээд, иргэнээс ирүүлсэн хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор хайгуул судалгаа хийж, техникийн шийдлийг гарган, комиссын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.

6.2 Техникийн нөхцөл олгох комиссын хуралдаанаас дараах шийдвэрүүдийн аль нэгийг гаргана.

- 6.2.1 Техникийн нөхцөл олгох боломжтой;

- 6.2.2 Техникийн нөхцөл олгох боломжгүй;
- 6.2.3 Техникийн нөхцөл боловсруулах хугацааг сунгах;
- 6.3 Дараах тохиолдолд техникийн нөхцөл олгох боломжгүй.
 - 6.3.1 Дамжуулах байгууламжийн ашиглалтын багтаамж дүүрсэн;
 - 6.3.2 Дамжуулах сүлжээнд холбогдоогүй;
 - 6.3.3 Хамгаалалтын зурвас газрыг тогтоох боломжгүй;
 - 6.3.4 Дамжуулах байгууламж, дэд бүтцэд ноцтой хохирол учруулах эрсдэл үүсэхээр бол;
 - 6.3.5 Авлигын шинжтэй үйлдэл гаргасан;
- 6.4 Дараах тохиолдолд техникийн нөхцөл боловсруулах хугацааг сунгана.
 - 6.4.1 Томоохон дэд бүтэц бүтээн байгуулалтыг шинээр барих, цар хүрээ ихтэй ажил;
 - 6.4.2 Шаардлагатай тохиолдолд захиалагч талтай хамтран газар дээр нь тодруулга хийх;
 - 6.4.3 Төрийн эрх бүхий байгууллагын шаардсанаар;

Долоо. Техникийн нөхцөлийг батлах, олгох

7.1 Техникийн нөхцөл олгох шийдвэр гарсан тохиолдолд шийдвэрийг нэн даруй баталгаажуулна.

7.2 Улаанбаатар хотод тухайн техникийн нөхцөлийг хариуцсан комиссын гишүүн боловсруулж, комиссын дарга хянаж, Технологийн удирдлага төлөвлөлт хариуцсан нэгжийн захирал танилцаж, гүйцэтгэх захирал баталснаар хүчин төгөлдөр болно.

7.3 Аймаг, дүүргийн газарт тухайн техникийн нөхцөлийг хариуцсан комиссын гишүүн боловсруулж, ерөнхий инженер хянаж, газрын дарга баталснаар хүчин төгөлдөр болно.

7.4 Батлагдсан техникийн нөхцөлийг хоёр хувь үйлдэж нэг хувийг нь хүсэлт гаргагчид хүлээлгэн өгнө.

Найм. Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа

8.1 “**LLC**”, “**IS**”, “**LC**”, “**OR**” төрлийн техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа нь батлагдсан өдрөөс хойш **30** хоног байна.

8.2 “**ESR**” төрлийн техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа нь батлагдсан өдрөөс хойш **45** хоног байна.

8.3 Худаг сувагчлал, кабель шугамын байгууламжийн сүлжээний өөрчлөлт богино хугацаанд хийгдэж байгаатай уялдуулан “А”, “В”, “С”, “D” төрлийн техникийн нөхцөлийн хүчинтэй байх хугацаа нь батлагдсан өдрөөс хойш 1 жил байна.

8.4 Зөвхөн хот, аймаг, дүүрэг, сум суурин газрыг хөгжүүлэхээр гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд шинээр баригдахаар хороолол хотхоны хэмжээний ажлын цар хүрээ их үед “С”, “D” төрлийн техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа нь батлагдсан өдрөөс хойш 2 жил байна.

Ес. Техникийн нөхцөлд өөрчлөлт оруулах, хугацааг сунгах, цуцлах

9.1 Техникийн нөхцөл эзэмшигчийн хүсэлтээр техникийн нөхцөлийг өөрчлөлт оруулах тохиолдолд хүчинтэй байгаа техникийн нөхцөлийг цуцлан дахин шинээр техникийн нөхцөл боловсруулан олгоно.

9.2 Энэхүү журмын 8.1, 8.2-т заасан техникийн нөхцөлийн хугацаа дуусахаас өмнө ажлын 5 хоногт хүсэлтээ өгч шийдвэрлүүлнэ.

9.3 Энэхүү журмын 8.3, 8.4-т заасан техникийн нөхцөлийн хугацаа дуусахаас нэг сарын өмнө хүсэлтээ өгч шийдвэрлүүлнэ.

9.4 Хугацаа дууссан техникийн нөхцөлийг сунгахгүй бөгөөд шинээр техникийн нөхцөл авах хүсэлт өгч шийдвэрлүүлнэ.

9.5 Техникийн нөхцөлийг дараах тохиолдолд цуцална. Үүнд:

9.5.1 Техникийн нөхцөлийн заалтыг зөрчсөн тохиолдолд;

9.5.2 Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа дуусахаас өмнө хугацаа сунгуулах хүсэлт ирүүлээгүй;

Арав. Техникийн нөхцөлийн үйлчилгээний хураамж

10.1 Техникийн нөхцөлийн үйлчилгээний хураамжийг Гүйцэтгэх захирлын баталсан тушаалын дүнгээр тооцно.

10.2 Техникийн нөхцөл олгохтой холбоотой хураамжийг хүсэлт гаргахдаа урьдчилж төлсөн байна.

10.3 Техникийн нөхцөл сунгах, өөрчлөлт оруулах тохиолдолд техникийн нөхцөлийн хураамжийн 50 хувийг төлнө.

10.4 Техникийн нөхцөл олгох боломжгүй тохиолдолд хураамжийг буцаан олгохгүй.

10.5 Төрийн болон албаны нууцтай холбоотой техникийн нөхцөл гаргах тохиолдолд хураамжийг техникийн нөхцөл гарсны дараа нэхэмжилж болно.

Арван нэг. “В”, “С”, “D” төрлийн техникийн нөхцөлийн дагуу гадна холбооны ажлын зураг зөвшилцөх

11.1 Захиалагч нь техникийн нөхцлийн дагуу гадны шугам сүлжээний ажлын зураг хийлгэхдээ ЗТ-6.4, ЗТ-7.4 ангилалын тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар хийлгэнэ.

11.2 Зураг төслийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, барилгын нормативын баримт бичгийг баримтлан зөвшилцөнө. Үүнд:

11.2.1 “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 5-р зүйлд заасны дагуу гүйцэтгэх;

11.2.2 Барилгын холбоожуулалтын ажлын төсвийн суурь норм БНБД 81-40-04;

11.2.3 Холбоо, радио, телевизийн байгууламжийн барилга угсралтын ажлын төсвийн норм БНБД 81-31-12;

11.2.4 Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04;

11.2.5 Холбооны кабель шугамын ажлын зураг төсөл MNS 6305:2012;

11.2.6 Мэдээлэл, холбооны сүлжээний гадна холбооны зургийн тэмдэглэгээ MNS 4908:2022;

11.2.7 Холбооны худаг сувагчлалын байгууламжийн техникийн үзүүлэлт, суурилуулалтын шаардлага MNS 6668:2017;

11.2.8 Бусад холбогдох барилгын норм ба дүрэм стандартууд;

11.3 Зураг төслийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, барилгын нормативын баримт бичгийг баримтлан зөвшилцөхдөө дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

11.3.1 Барилгын зураг төсөл зохиох бусад норм норматив, үнэлгээний заавар дүрмийг үндэслэх;

11.3.2 Ажлын зурагт дохиолол, домофон систем, телефон холбоо, кабелийн телевиз, интернэт, хяналтын систем, шинэ үйлчилгээний тоног төхөөрөмжүүдийг байршуулах техникийн өрөө ба байрыг хотхон, хорооллын төв хэсэг болон оновчтой байршилд зайлшгүй төлөвлөх;

11.3.3 Зураг төсвийн техникийн зургийг шаардлага хангасан өндөржилт, инженерийн шугам сүлжээний байршлыг оруулан М1:500 масштабын дэвсгэр зураг дээр гүйцэтгэх;

11.3.4 Техникийн зурагт кабель сувагчлалын трассыг аль болохоор механик гэмтэлд өртөхөөргүй, газар ашиглалтын боломж нөхцөлийг хангасан байдлаар тогтоож инженерийн бусад шугам сүлжээний огтлолцлыг зүсэлтээр

харуулж ашиглалтын аюулгүй ажиллагааны шаардлага хангасан байхаар тусгах;

11.3.5 Сувагчлал шинээр хийх тохиолдолд улаан шугамын дагуу трассын байршлыг тогтоосон зураг гаргаж баталгаажуулан акт үйлдэж, гүйцэтгэгч нарт өгөх;

11.3.6 Техникийн нөхцөлийн дагуу гаргасан ажлын зургийг тухайн аймаг, хот, дүүргийн ерөнхий төлөвлөгөөний газрын холбоо хариуцсан мэргэжилтэн болон техникийн нөхцөл боловсруулан олгосон байгууллагаар хянуулан баталгаажуулах ба мөн бусад инженерийн байгууллагуудаар тодорхойлолт хийлгэх;

11.3.7 “Зураг төсөл, хайгуул судалгааны ажилд улсын экспертиз хийх дүрэм”-ийг үндэс болгон эрх бүхий аж ахуй нэгжээр экспертизээр хянуулж магадлалын дүгнэлт гаргуулах;

11.3.8 Барилгын дотор холбооны шугамыг зураг төсөвт заавал оруулах;

11.4 Улаанбаатар хотод тухайн ажлын зургийг зөвшилцөхөд техник нөхцөлийн дагуу техникийн шийдлийг хариуцсан ажилтан хянаж, Технологийн удирдлага төлөвлөлт хариуцсан газрын захирал баталснаар хүчин төгөлдөр болно.

11.5 Аймаг, дүүргийн газарт тухайн тухайн ажлын зургийг зөвшилцөхөд техник нөхцөлийн дагуу техникийн шийдлийг ерөнхий инженер хянаж, газрын дарга баталснаар хүчин төгөлдөр болно.

Арван хоёр: Газар шорооны ажлын тодруулга авах

12.1 Зам гүүр, бусад инженерийн байгууламжийн шугам сүлжээний өргөтгөл засвар, шинээр баригдаж буй барилга байгууламжууд, тэдгээрийн байршил өөрчлөгдөх үед МХС-ийн эзэмшлийн хот хоорондын шилэн кабелийн трасс, барилга, цамхаг, худаг сувагчлал, агаарын багана, кабель шугамын байгууламжуудтай огтлолцох, давхцах, хамгаалалтын зурваст орж байгаа талаарх ажлын зурагт тодруулга авна.

12.2 Газар шорооны ажлын тодруулгыг авах хуулийн этгээд, иргэний баримт бичгийг үндэслэн ажлын 3 хоногт багтаан шийдвэрлэнэ.

12.3 Захиалагч нь Мэдээлэл холбооны сүлжээ ХХК -ийн эзэмшлийн сүлжээ, дэд бүтцийг шилжүүлэх шаардлага гарвал “С” - худаг сувагчлал, кабель шугамын байгууламжийг хамгаалах, шинээр хийх, шилжүүлэх техникийн нөхцөл болон техникийн даалгавар гаргуулан дээрх шаардлагууд болон Харилцаа холбооны тухай хуулийг мөн адил мөрдөн, угсралтын ажлыг гүйцэтгэнэ.

12.4 Захиалагч нь тодруулгын төлбөрийн хураамжийг Гүйцэтгэх захирлын баталсан тушаалын дүнгээр тооцно.

Арван гурав. Ажил эхлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих

13.1 “LLC”, “IS”, “LC”, “OR”, “ESR” төрлийн техникийн нөхцөл эзэмшигчид гэрээ байгуулсны дараа холболт, угсралт суурилуулалт хийх зөвшөөрөл олгоно.

13.2 “A”, “B”, “C”, “D” төрлийн техникийн нөхцөлийн дагуу харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллага нь ажил эхлэх зөвшөөрлийг авахад дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

13.2.1 Аж ахуйн нэгж байгууллагын албан бичиг, хүсэлт;

13.2.2 Техникийн нөхцөлийн хуулбар, (“A” техникийн нөхцөл, хавсралт зураг);

13.2.3 Гадна холбооны ажлын зураг;

13.3 Ажил эхлэх зөвшөөрлийг хүсэлт гаргаснаас хойш ажлын 3 хоногт олгоно.

13.4 Ашиглалт хариуцсан газар нэгжүүд тухайн ажлыг, техникийн нөхцөл, ажлын зураг, ажил эхлүүлэх зөвшөөрлийн дагуу хийгдэж байгаа эсэхэд чанар хяналтыг хийж гүйцэтгэгчид шаардлага тавина.

13.5 Харилцагч гэрээнд өөрчлөлт оруулах тохиолдолд албан хүсэлт гарган ажиллах зөвшөөрөл авсан байна.

Арван дөрөв. Гүйцэтгэлийг техникийн актаар хүлээн авах

14.1 “LLC”, “IS”, “LC”, “OR”, “ESR” төрлийн техникийн нөхцөлийн дагуу хийсэн гүйцэтгэлд захиалагч, гүйцэтгэгч, ашиглалт хариуцсан нэгжүүд акт үйлдэн баталгаажуулна.

14.2 “A” төрлийн техникийн нөхцөлийн дагуу хийсэн ажлыг ашиглалтад хүлээлгэн өгөхдөө дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

14.2.1 Техникийн нөхцөлийн хуулбар;

14.2.2 Гэрээний хуулбар;

14.2.3 Ажил эхлэх зөвшөөрөл;

14.2.4 Шилэн кабелийн акт M-107;

14.2.5 Автокадын гүйцэтгэлийн зураг;

14.3 “B”, “C”, “D” төрлийн техникийн нөхцөлийн ажлын гүйцэтгэлийн акт хүлээлгэн өгөхөд дараах нийтлэг материалыг бүрдүүлнэ. Үүнд:

14.3.1 Техникийн нөхцөлийн хуулбар;

14.3.2 Гадна холбооны баталгаажсан ажлын зураг;

14.3.3 Ажил эхлэх зөвшөөрөл;

14.3.4 Сувагчлалын далд ажлын акт М-100, фото зургуудын хамт;

14.3.5 Шинэ хүлээн авалтын акт М-102;

14.3.6 Кабелийн шөрмөсний залгааны акт М-101;

14.3.7 Хэмжүүрийн протокол;

14.3.8 Оруулгын паспорт, худгийн паспорт, хуваарилах шүүгээний техникийн паспорт;

14.3.9 Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэл;

14.3.10 Гүйцэтгэлийн зураг;

14.3.11 Шинэ барилга байгууламжийн гадна холбооны худаг сувагчлалыг аймаг, хот, дүүргийн мэдээллийн санд оруулсан тухай акт, зураг, CD-ны хамт ирүүлэх;

14.4 Энэхүү журмын 13.5-т заасан ажлыг "F" актыг үндэслэн гэрээнд өөрчлөлт оруулна.

Арван тав. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисст ажиллах

15.1 "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах" дүрмийг баримтлан ажиллана.

15.2 Барилга байгууламж, угсралтын ажлыг ашиглалтад хүлээж авахад Мэдээллийн холбооны сүлжээ ХХК нь хангагч байгууллагаар оролцох ба Улаанбаатар хотод комиссын гишүүнийг Гүйцэтгэх захирлын тушаалаар, аймаг дүүргийн газруудад газрын даргын тушаалаар томилно.

15.3 Гадна болон дотор ажлын зураг, төсөв тэдгээрийн угсралт суурилуулалтын угсралтын ажил, холбоо дохиолол, домофон систем, телефон холбоо, кабелийн телевиз, интернэт, хяналтын систем, шинэ үйлчилгээний тоног төхөөрөмжүүдийн ажиллагаа, тэдгээрийн холбогдох баримт бичиг, стандарт шаардлагыг хангасан эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, улсын комиссын хурлын шийдвэрийг үндэслэн үүрэг даалгаврын биелэлтээр хүлээж авна.

Арван зургаа: Хариуцлага

16.1 Шинээр ашиглалтад хүлээн авсан худаг сувагчлал, кабель шугамын баталгаат засварын 2 жилийн хугацаанд технологийн зөрчлөөс шалтгаалж гарсан гэмтэл саатлыг тухайн ажлыг хийсэн гүйцэтгэгч компани хариуцаж арилгана. Худаг сувагчлал, кабель шугамын байгууламжийг актаар хүлээлгэн өгсний дараа (хэрэглэгч холбогдсон физик кабельд) гарсан технологийн зөрчлөөс бусад гэмтэл

саатал, ажлуудыг Мэдээлэл холбооны сүлжээ компани ХХК (аймаг, дүүргийн болон ашиглалтын газар) хариуцна.

16.2 Шилэн кабель татахдаа техникийн нөхцөлд заасан худаг сувагчлал, газрын трассаар татаагүй, стандарт технологийн шаардлага хангаагүйгээс болсон кабелийг буцаан авах, өөр кабелиар солиход үүссэн асуудлыг болон холбогдох зардлыг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК хариуцахгүй болно.

16.3 Холбооны худаг сувагчлалын байгууламж, кабель шугамын байгууламжид ажиллахаар зөвшөөрөл авч ажил гүйцэтгэх явцад бусад иргэн, хуулийн этгээдийн эзэмшлийн кабель шугамыг гэмтээсэн тохиолдолд гэмтлийг засварлах болон бусад зардлыг буруутай этгээд хариуцна.

16.4 Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.


Арван долоо. Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх

17.1 Компанийн ажилтан, комиссын гишүүд авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна. (Компанийн ажилтанд удирдах ажилтан, мэргэжилтэн, ажилтан, инженер техникийн ажилтнууд хамаарна)

17.2 Авлига ашиг сонирхлын зөрчил бий болох нөхцөл үүссэн тохиолдолд шууд удирдах албан тушаалтанд мэдэгдэх үүрэгтэй.

17.3 Нэгдмэл сонирхолтой болон хамаарал бүхий этгээдэд техникийн нөхцөл олгох тохиолдолд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай мэдэгдлийг бөглөсөн байна.


“Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын
2022 оны 02 сарын 27-ны өдрийн
А/92 дугаар тушаалын Хоёрдугаар хавсралт



Техникийн нөхцөлийн маягт

| № | Төрөл | Улаанбаатар хот | Аймаг дүүргийн газрууд |
|---|--|-----------------|------------------------|
| 1 | “LLC” E1 сувгийн техникийн нөхцөл | Маягт-1 | |
| 2 | “LLC” дата сувгийн болон “IS” интернэтийн бөөний үйлчилгээний техникийн нөхцөл | Маягт-2 | |
| 3 | “LC” Шилэн кабелийн шөрмөс түрээслүүлэх үйлчилгээ | Маягт-3 | |
| 4 | “ESR”-Тоног төхөөрөмжийн байр талбай, цамхаг түрээслүүлэх техникийн нөхцөл | Маягт-4 | Маягт-5 |
| 5 | OR”- Дэд бүтэц, барилга байгууламж, түрээсээр ашиглуулах | Маягт-6 | Маягт-7 |
| 6 | “А”- Сувагчлалаар шилэн кабель суурилуулах | Маягт-8 | Маягт-9 |
| 7 | В”-Худаг сувагчлал байгуулах, физик кабель суурилуулах | Маягт-10 | Маягт-11 |
| 8 | С”-Худаг сувагчлал, кабелийн шилжүүлэг | Маягт-12 | Маягт-13 |
| 9 | “D”-Худаг сувагчлал байгуулах | Маягт-14 | Маягт-15 |


“Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын
2022 оны 08 сарын 27-ны өдрийн
А/94 дугаар тушаалын Гуравдугаар хавсралт



Ажил эхлүүлэх зөвшөөрлийн маягт

| № | Зөвшөөрөл | Улаанбаатар хот | Аймаг дүүргийн газрууд |
|---|------------------------------|-----------------|------------------------|
| 1 | “LLC”, “IS”, “LC”- зөвшөөрөл | Маягт-16 | |
| 2 | “ESR”- зөвшөөрөл | Маягт-17 | Маягт-18 |
| 3 | “OR”- зөвшөөрөл | Маягт-19 | Маягт-20 |
| 4 | “А” - зөвшөөрөл | Маягт-21 | Маягт-22 |
| 5 | “В”, “С”, “D”- зөвшөөрөл | Маягт-23 | Маягт-24 |

“Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын
2022 оны 08 сарын 27-ны өдрийн
А/92 дугаар тушаалын Дөрөвдүгээр хавсралт



Гүйцэтгэлийг хүлээж авах актын маяг

| № | Зөвшөөрөл | Улаанбаатар хот | Аймаг дүүргийн газрууд |
|---|-----------------------|-----------------|------------------------|
| 1 | “LLC”, “IS”, “LC” акт | Маягт-25 | |
| 2 | “ESR”- акт | Маягт-26 | Маягт-27 |
| 3 | “OR”- акт | Маягт-28 | Маягт-29 |
| 4 | “F” акт | Маягт-30 | Маягт-31 |
| 5 | M-100 акт | Маягт-32 | Маягт-33 |
| 6 | M-101 акт | Маягт-34 | Маягт-35 |
| 7 | M-102 акт | Маягт-36 | Маягт-37 |
| 8 | M-107 акт | Маягт-38 | Маягт-39 |